ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 336.06 нэгжээр буюу 1.71 хувиар буурч, 19285.80 нэгж болсон байна. Индексийн бууралтад индексийн сагсыг бүрдүүлж буй МОНГОЛ БАЗАЛЪТ ХК /-30.29%/, ГОВЬ ХК /-28.70%/, ЛЭНДМН ББСБ ХК /-26.40%/, ШАРЫН ГОЛ ХК /-22.03%/ -ийн ханш тус тус буурсан нь нөлөөлсөн байна.



## MSE A, MSEB индекс

МХБ нь 2018 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн MSE A, MSE B индексийг албан ёсоор тооцож байгаа билээ. Тайлант хугацаанд MSE A индексийн дээд үзүүлэлт нь 9,500.09 нэгж, доод үзүүлэлт нь 7,447.15 нэгж, дундаж үзүүлэлт нь 8,318.94 нэгж, харин MSE B индексийн хувьд дээд үзүүлэлт нь 7,917.73 нэгж, доод үзүүлэлт нь 7,223.27 нэгж, дундаж үзүүлэлт нь 7,493.83 нэгж тус тус байна.

**2019 ОНЫ ҮНЭТ ЦААСНЫ  
АРИЛЖААНЫ ТАЙЛАН**

## 2019 ОНЫ ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ТАЙЛАН

### 1. Үнэт цаасны арилжаа

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 251 удаагийн арилжаагаар 132 компанийн 450.3 сая ширхэг хувьцааг 133.5 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 97.4 мянган ширхэг үнэт цаасыг 9.7 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 143.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Нийт гүйлгээний үнийн дүнгийн 93.3%-ийг хувьцааны арилжааны гүйлгээний дүн, 6.7%-ийг ЗГҮЦ-ны арилжааны гүйлгээний дүн тус тус эзэлж байна.

Хүснэгт 1. Үнэт цаасны арилжаа /2019.12.31-ний байдлаар/

Үнэт цаасны төрөл		Арилжигдсан тоо хэмжээ /мянган ширхэг/	Арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг/
Хувьцаа	Анхдагч зах зээл	253.4	42.4
	Хоёрдогч зах зээл	196.9	91.1
ЗГҮЦ	Хоёрдогч зах зээл	0.097	9.7
<b>Нийт</b>		<b>450.4</b>	<b>143.2</b>

Тайлант хугацаанд өдөрт дунджаар 570.5 сая төгрөгийн гүйлгээ хийгдэж, 1.8 сая ширхэг үнэт цаас арилжигдсан байна.

Арилжаалагдсан үнэт цаасны үнийн дүнг сүүлийн 5 жилээр харьцуулан харуулбал:  
/Хүснэгт 2/

Хүснэгт 2.

Үнэт цаасны нэр	2015 он	2016 он	2017 он	2018 он	2019 он
Хувьцаа /тэрбум төг/	30.5	49.0	76.4	210.0	133.5
ЗГҮЦ /тэрбум төг/	515.5	299.6	772.5	33.5	9.7
Компанийн бонд /тэрбум төг/	0.5	0	10.2	0.6	0

### 1.1 Хувьцааны арилжаа


Тайлант хугацаанд нийт 251 удаагийн арилжаагаар 132 компанийн 450.3 сая ширхэг хувьцааг 133.5 тэрбум төгрөгөөр арилжаалсан. Хувьцааны арилжааны 41.87% буюу 55.9 тэрбум төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, 31.8% буюу 42.4 тэрбум төгрөгийн гүйлгээг анхдагч зах зээлийн арилжаа, 3.5% буюу 4.6 тэрбум төгрөгийг тендер арилжаа, 22.8% буюу 30.5 тэрбум төгрөгийг энгийн арилжаа тус тус эзэлж байна.

Дараах графикаар хувьцааны арилжааны үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулав. /График 1/

График 1.

## Хувьцааны арилжаа /үнийн дүнгээр/

Багцын арилжаа



Тайлант хугацаанд багцын арилжаагаар Хот девелопмент, Хөвсгөл алтандуулга, Лэндмн ББСБ, Баялаг-Сүмбэр, Түмэн шувуут, Хүннү менежмент, Даваанбулаг, Мон-Ит Булигаар, Мик холдинг, АПУ, Инвескор ББСБ, Улаанбаатар хивс зэрэг ХК-иудын нийт 48.2 сая ширхэг хувьцааг 55.9 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 41.87%-ийг эзэлж байна.

### Тендер саналын арилжаа

Тайлант хугацаанд тендер саналын арилжаагаар "Мон-Ит Булигаар" ХК-ийн 6,301 ширхэг хувьцааг хувьцааг 47.4 сая төгрөгөөр, "Атар Өргөө" ХК-ийн 76,756 ширхэг хувьцааг 4.6 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна.

### Анхдагч зах зээлийн арилжаа

Тайлант хугацаанд хувьцааны анхдагч зах зээлд нийт 4 компанийн 42.4 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 253.4 сая ширхэг хувьцааг нийтэд санал болгон амжилттай арилжсан байна. Үүнд: 2018 оны 2 дугаар сард "Түмэн шувуут" ХК-ийн 50.0 сая ширхэг хувьцааг 10.0 тэрбум төгрөгөөр, 3 дугаар сард "Ард кредит ББСБ" ХК-ийн 70.0 сая ширхэг хувьцааг 5.2 тэрбум төгрөгөөр, 5 дугаар сард "Монос хүнс" ХК-ийн 122.6 сая ширхэг хувьцааг 8.5 тэрбум төгрөгөөр, 6 дугаар сард "Инвескор ББСБ" ХК-ийн 10.7 сая ширхэг хувьцааг 18.5 тэрбум төгрөгөөр анхдагч зах зээлд амжилттай арилжсан байна.

## Нийт хувьцааны арилжаанд эзлэх хувь



### Идэвхтэй арилжигдсан 20 үнэт цаас

ҮНЭТ ЦААС	ШИРХЭГ	ЭРЭМБЭ	ҮНЭТ ЦААС	ҮНИЙН ДҮН
ЛЭНДМН ББСБ ХК	52,938,398	1	МИК ХОЛДИНГ	30,561,483,100.00
АРД КРЕДИТ ББСБ ХК	34,727,992	2	АПУ	22,693,098,210.94
АПУ	32,748,227	3	АТАР-ӨРГӨӨ	4,637,814,600.00
МОНОС ХҮНС	13,851,565	4	ЛЭНДМН ББСБ ХК	3,432,178,057.81
МАНДАЛ ДААТГАЛ	12,754,171	5	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	3,078,478,606.00
ТҮМЭН ШУВУУТ	9,326,402	6	АРД КРЕДИТ ББСБ ХК	2,742,036,849.09
ГОВЬ	7,844,014	7	ИНВЕСКОР ББСБ	2,517,235,181.00
РЕМИКОН	5,002,841	8	ГОВЬ	2,367,153,415.39
МОНГОЛ БАЗАЛТ ХК	3,316,165	9	МОН-ИТ БУЛИГААР	2,265,040,032.00
АРД ДААТГАЛ ХК	3,124,533	10	АРД ДААТГАЛ ХК	2,176,785,588.11
ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	2,480,241	11	МАНДАЛ ДААТГАЛ	2,112,955,294.30
МИК ХОЛДИНГ	2,180,054	12	ХӨВСГӨЛ АЛТАН ДУУЛГА	2,103,676,800.36
АЙТҮҮЛС	2,121,760	13	ТҮМЭН ШУВУУТ	1,755,472,855.11
СҮҮ	2,054,602	14	ТАВАН ТОЛГОЙ	1,614,683,060.00
АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	1,986,569	15	МОНОС ХҮНС	964,429,419.17
ДАВААНБУЛАГ	1,729,069	16	МОНГОЛ БАЗАЛТ ХК	962,731,108.74
ИНВЕСКОР ББСБ	1,291,095	17	МОНГОЛ ШУУДАН ХК	607,914,963.13
НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	1,207,252	18	УЛААНБААТАР ХИВС	557,943,080.00
МОНГОЛ ШУУДАН ХК	1,043,044	19	ШАРЫН ГОЛ	513,106,837.00
МОНИНЖБАР	573,838	20	БИ ДИ СЕК	414,131,681.61
<b>НИЙТ</b>	<b>192 301 832</b>			<b>88,078,348,739.76</b>
<b>НИЙТЭД ЭЗЛЭХ ХУВЬ</b>	<b>97.67%</b>			<b>96.73%</b>

Идэвхтэй арилжигдсан 20 үнэт цаасны тоо ширхэг нь нийт арилжигдсан ширхэгийн 97.67 хувь, үнийн дүнгийн 96.73 хувийг тус тус эзэлж байна.

### Ханшийн өсөлттэй 20 компани

Симбол	Үнэт цаас	2018.12.31	2019.12.31	Ханшийн өөрчлөлт /төг/	Ханшийн өөрчлөлт /%/
DAR	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	920	4243	3323	361.20
HBZ	ХҮННҮ МЕНЕЖМЕНТ	185	427.89	242.89	131.29

BOE	ЭРЧИМ БАЯН ӨЛГИЙ	460	1000	540	117.39
HRD	ХҮРД	2128	4279	2151	101.08
UID	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	500	977.53	477.53	95.51
TAV	ТАВ	10000	17500	7500	75.00
DZG	ДАРХАН ЗОЧИД БУУДАЛ	90	150	60	66.67
MDR	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	205	338.44	133.44	65.09
HCH	Е-МОНИЕ	1286	1954	668	51.94
VIK	БАЯН-АЛДАР	700	1000	300	42.86
INV	ИНВЕСКОР ББСБ	1600	2198	598	37.38
BTG	БАЯНТЭЭГ	18280	25000	6720	36.76
HBO	ХАЙ БИ ОЙЛ	52	70	18	34.62
HSR	ХАСУ-МАНДАЛ	5750	7460	1710	29.74
BHL	БӨӨНИЙ ХУДАЛДАА ХК	390	500	110	28.21
HZB	ГАН ХЭРЛЭН	4413	5320	907	20.55
BUK	УБ-БУК	385	458	73	18.96
CHE	ХОРГО ХАЙРХАН	60	70	10	16.67
ETR	Э-ТРАНС ЛОЖИСТИКС	120	139	19	15.83
HUT	ХӨДӨӨГИЙН ТЭЭВЭР	4000	4600	600	15.00

### Ханшийн бууралттай 20 компани

Симбол	Үнэт цаас	2018.12.28	2019.12.31	Ханшийн өөрчлөлт /төг/	Ханшийн өөрчлөлт /%/
ONH	ӨНДӨРХААН	11040	1390	-9650	-87.41
SON	СТАНДАРТ АГРИКАЛЧЕР ГРУПП	270	90	-180	-66.67
NKT	НАКО ТҮЛШ	109.7	37	-72.7	-66.27
BBD	СТАНДАРТ ПРОПЕРТИ ГРУПП	170	70	-100	-58.82
NUR	НИЙСЛЭЛ ӨРГӨӨ	8500	3700	-4800	-56.47
HRL	ХЭРЛЭН ХИВС	101.2	45	-56.2	-55.53
TEX	ТЕХНИК ИМПОРТ	17900	8000	-9900	-55.31
GTJ	БУЛГАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	1600	750	-850	-53.13
ADL	АДУУН ЧУЛУУН	2100	1180	-920	-43.81
TSA	ЦАГААНТОЛГОЙ	2776	1625	-1151	-41.46
BHG	БӨХӨГ	3300	1950	-1350	-40.91
DHU	ДАРХАН ХҮНС	4300	2560	-1740	-40.47
DRU	ДӨРВӨН-УУЛ	1300	775	-525	-40.38
LEND	ЛЭНДМН ББСБ ХК	71	42.72	-28.28	-39.83
SHG	ШАРЫН ГОЛ	1801	1134	-667	-37.03
SIL	СИЛИКАТ	105	68	-37	-35.24
ITLS	АЙТҮҮЛС	111.6	72.36	-39.24	-35.16
AAR	АВТО ЗАМ	5180	3400	-1780	-34.36
JLT	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	132	90	-42	-31.82
TEE	ТЭЭВЭР ДАРХАН	12600	8625	-3975	-31.55

### 1.2 ЗГҮЦ-ны арилжаа

Тайлант хугацаанд ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй бөгөөд хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 97.4 мянган ширхэг үнэт цаас 9.7 тэрбум төгрөгөөр арилжигдсан байна.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаанд “Новел инвестмент”, “Мирэ Эссет Секьюритис Монгол”, “Голомт капитал”, “Тэнгэр капитал”, “Стандарт инвестмент”, “Гаүли”, “Централ секьюритийз”, “Стандарт инвестмент” зэрэг ҮЦК-иуд идэвхитэй оролцсон байна.


## 2.Зах зээлийн индикаторууд

Үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлдог гол индикатор болох Зах зээлийн үнэлгээ, Топ-20 индекс, мөн 2018 оны 2 дугаар сараас тооцож эхэлсэн MSE A, MSE B индексүүдийг 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулав.

### Зах зээлийн үнэлгээ

2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар МХБ-д бүртгэлтэй олон нийтэд хувьцаа нь арилжигдаж буй компаниудын нийт зах зээлийн үнэлгээ нь 2 их наяд 690 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 182.3 тэрбум төгрөгөөр буюу 7.27 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ.

График 3. Зах зээлийн үнэлгээ /сүүлийн 5 жилээр/



## Хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй 30 компани

д/д	Компанийн нэрс	Зах зээлийн үнэлгээ
1	АПУ	675,946,838,834.54
2	ТАВАН ТОЛГОЙ	342,323,800,000.00
3	МИК ХОЛДИНГ	310,639,800,000.00
4	ГОВЬ	210,630,375,000.00
5	ИНВЕСКОР ББСБ	157,657,963,764.00
6	МОНГОЛ ШУУДАН ХК	72,200,113,175.00
7	СҮҮ	72,002,640,000.00
8	УБ-БҮК	60,248,755,000.00
9	ЕВРОАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ	60,111,525,800.00
10	АРД САНХҮҮГИЙН НЭГДЭЛ	50,532,788,458.00
11	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	35,980,777,610.50
12	ШИВЭЭ ОВОО	34,352,898,560.00
13	ЛЭНДМН ББСБ ХК	34,176,000,000.00
14	ТҮМЭН ШУВУУТ	32,456,000,000.00
15	МАНДАЛ ДААТГАЛ	31,458,557,624.00
16	МОНОС ХҮНС	28,742,185,088.40
17	ГУТАЛ	25,898,944,000.00
18	АРД КРЕДИТ ББСБ ХК	22,951,600,000.00
19	АРД ДААТГАЛ ХК	19,998,750,000.00
20	БАЯН-АЛДАР	19,922,679,000.00
21	БАГАНУУР	19,920,608,153.60
22	ТАХЬ-КО	15,588,777,300.00
23	ТАЛХ ЧИХЭР	15,580,759,660.00
24	ДАРХАН НЭХИЙ	15,454,596,420.00
25	МОНГОЛ БАЗАЛТ ХК	14,596,770,410.00
26	БИ ДИ СЕК	14,450,000,000.00
27	БЭРХ УУЛ	13,152,835,200.00
28	МАТЕРИАЛИМПЕКС	12,505,402,840.00
29	ТЕХНИК ИМПОРТ	11,574,040,000.00
30	ШАРЫН ГОЛ	11,533,054,428.00
<b>Нийт</b>		<b>2,442,589,836,326.04</b>
<b>Нийтэд эзлэх хувь</b>		<b>90.79%</b>

### ТОП-20 индекс

Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 21888.16 нэгж, доод үзүүлэлт 17922.82 нэгж, дундаж үзүүлэлт 19978.13 нэгж байна.


ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1844.90 нэгжээр буюу 8.59 хувиар буурч, 19621.86 нэгж болсон байна. Индексийн бууралтад индексийн сагсыг бүрдүүлж буй “Лэнд мн ББСБ” ХК /39,8%/, Ай түүлс ХК /35,1%/, Дархан нэхий ХК /22,3%/, Талх чихэр ХК /21,1%/, Хөвсгөл алтандуулга ХК /16,3%/, Таван толгой ХК /9,8%/-ийн ханш тус тус буурсан нь нөлөөлсөн байна.





### MSE A, B индекс

МХБ нь 2018 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн MSE A, B индексийг албан ёсоор тооцож эхлээд байгаа билээ. Тайлант хугацаанд MSE A индексийн дээд үзүүлэлт нь 10268.81 нэгж, доод үзүүлэлт нь 8,163.84 нэгж, дундаж үзүүлэлт нь 9,247.29 нэгж, харин MSE B индексийн хувьд дээд үзүүлэлт нь 8,860.92 нэгж, доод үзүүлэлт нь 7,335.38 нэгж, дундаж үзүүлэлт нь 7,984.80 нэгж тус тус байна.



**2018 ОНЫ ҮНЭТ ЦААСНЫ  
АРИЛЖААНЫ ТАЙЛАН**

## 2018 ОНЫ ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ТАЙЛАН

### 2. Үнэт цаасны арилжаа

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 252 удаагийн арилжаагаар 136 компанийн 666.8 сая ширхэг хувьцааг 210.0 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаагаар 332.8 мянган ширхэг үнэт цаасыг 33.5 тэрбум төгрөгөөр, компанийн бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар 6.3 мянган ширхэг бондыг 631.6 сая төгрөгөөр тус тус арилжиж, нийт 244.1 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Нийт гүйлгээний үнийн дүнгийн 86.02%-ийг хувьцааны арилжааны гүйлгээний дүн, 13.72%-ийг ЗГҮЦ-ны арилжааны гүйлгээний дүн, 0.26%-ийг компанийн бондын арилжааны гүйлгээний дүн тус тус эзэлж байна.

Хүснэгт 1. Үнэт цаасны арилжаа /2018.12.31-ний байдлаар/

Үнэт цаасны төрөл		Арилжигдсан тоо хэмжээ /сая ширхэг/	Арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг/
Хувьцаа	Анхдагч зах зээл	240.3	31.4
	Хоёрдогч зах зээл	426.5	178.6
ЗГҮЦ	Хоёрдогч зах зээл	0.33	33.5
Компанийн бонд	Хоёрдогч зах зээл	0.01	0.6
<b>Нийт</b>		<b>667.2</b>	<b>244.1</b>

Тайлант хугацаанд өдөрт дунджаар 968.8 сая төгрөгийн гүйлгээ хийгдэж, 2.6 сая ширхэг үнэт цаас арилжигдсан байна.

Арилжаалагдсан үнэт цаасны үнийн дүнг сүүлийн 4 жилээр харьцуулан харуулбал: /Хүснэгт 2/

Хүснэгт 2.

Үнэт цаасны нэр	2015 он	2016 он	2017 он	2018 он
Хувьцаа /тэрбум төг/	30.5	49.0	76.4	210.0
ЗГҮЦ /тэрбум төг/	515.5	299.6	772.5	33.5
Компанийн бонд /тэрбум төг/	0.5	-	10.2	0.6

#### **1.1 Хувьцааны арилжаа**

Тайлант хугацаанд нийт 252 удаагийн арилжаагаар 136 компанийн 666.8 сая ширхэг хувьцааг 210.0 тэрбум төгрөгөөр арилжаалсан байна. Хувьцааны арилжааны 15.0% буюу 31.4 тэрбум төгрөгийн гүйлгээг анхдагч зах зээлийн арилжаа, 85.0% буюу 178.6 тэрбум төгрөгийн гүйлгээг хоёрдогч зах зээлийн арилжаа эзэлж байна.

Тайлант хугацаанд нийт 210.0 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийсэн нь түүхэн дэх хамгийн их үнийн дүн бүхий арилжаа болсон бөгөөд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 133.6 тэрбум төгрөгөөр буюу 174.7 хувиар өссөн үзүүлэлттэй байна./График1/




/График1/

Дараах графикаар хувьцааны арилжааны үнийн дүнг өмнөх оны мөн үетэй харьцуулав.  
/График 2/

#### Хувьцааны арилжаа /үнийн дүнгээр/

/График 2/

Багцын арилжаа



Тайлант хугацаанд багцын арилжаагаар Лэндмн ББСБ, Дархан нэхий, МЦХ, Мик холдинг, АПУ зэрэг ХК-иудын нийт 161.2 сая ширхэг хувьцааг 127.4 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 60.6%-ийг эзэлж байна. /График 3/

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдөр “АПУ” ХК-ийн 117.2 сая ширхэг буюу 11%-ийг 84.4 тэрбум төгрөгөөр арилжсан нь түүхэн дэх хамгийн их үнийн дүн бүхий багцын арилжаа боллоо.

/График 3/



Үнэт цаас	Арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг/							
	2015 он		2016 он		2017 он		2018 он	
	энгийн	багцын	энгийн	багцын	энгийн	багцын	энгийн	багцын
Хувьцаа	27.3	3.1	14.9	34.1	31.8	44.6	82.6	127.4

#### Тендер саналын арилжаа

Тайлант хугацаанд Монгол Улсын Засгийн Газар нь "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн хувьцааны хяналтын багцыг дангаараа эзэмшигч болсон тул "Компанийн тухай" хуулийн 57.1, "Үнэт цаасны зах зээлийн тухай" хуулийн 22.1.2 болон СЗХ-ны "Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны журам"-ыг үндэслэн үүргээ хэрэгжүүлэх үндсэн дээр "Монголын цахилгаан холбоо" ХК-ийн бусад жижиг хувьцаа эзэмшигчдийн үнэт цаасыг худалдаж авах санал гаргасан бөгөөд тус арилжаагаар 7.5 мянган ширхэг хувьцааг 4.1 сая төгрөгөөр арилжсан байна.

#### Анхдагч зах зээлийн арилжаа

Тайлант хугацаанд хувьцааны анхдагч зах зээлд нийт 7 компанийн 31.4 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 240.3 сая ширхэг хувьцааг нийтэд санал болгон амжилттай арилжсан байна.

Үүнд: 2018 оны 3 дугаар сард "Лэндмн ББСБ" ХК-ийн 200.0 сая ширхэг хувьцааг 5.0 тэрбум төгрөгөөр, 5 дугаар сард "Монгол Базальт" ХК-ийн 16.9 сая ширхэг хувьцааг 6.4 тэрбум төгрөгөөр, 6 дугаар сард "Эрдэнэ Ресурс Девелопмент" ХК-ийн 3.9 сая ширхэг хувьцааг 2.5 тэрбум төгрөгөөр, 9 дүгээр сард "Хөвсгөл Алтандуулга" ХК-ийн нэмж гаргасан 4.4 сая ширхэг хувьцааг 3.7 тэрбум төгрөгөөр, "Мандал даатгал" ХК-ийн 1.5 сая ширхэг хувьцааг 7.5 тэрбум төгрөгөөр, "Ард даатгал" ХК-ийн 7.5 сая ширхэг хувьцааг 5.2 тэрбум төгрөгөөр, 10 дугаар сард "Цемент шохой" ХК-ийн хаалттай хүрээнд нэмж гаргасан 6.0 сая ширхэг хувьцааг 1.0 тэрбум төгрөгөөр анхдагч зах зээлд амжилттай арилжаад байна.

#### Идэвхтэй арилжигдсан 20 үнэт цаас

ҮНЭТ ЦААС	ШИРХЭГ	ЭРЭМБЭ	ҮНЭТ ЦААС	ҮНИЙН ДҮН
ЛэндМН ББСБ	167,597,032	1	АПУ	92,375,598,444
АПУ	130,065,842	2	МИК ХОЛДИНГ	31,382,026,400
ХАЙ БИ ОЙЛ	28,825,477	3	ЛэндМН ББСБ	8,773,801,485
АЙТҮҮЛС	12,225,369	4	МОН.ЦАХИЛГААН ХОЛБОО	6,579,732,233
ЖЕНКО ТУР БЮРО	11,822,843	5	ТАВАН ТОЛГОЙ	4,403,533,030
МОН.ЦАХИЛГААН ХОЛБОО	11,257,834	6	ГОВЬ	4,316,320,014
МОНГОЛ БАЗАЛЪТ	8,841,509	7	ДАРХАН НЭХИЙ	4,052,753,180
НАКО ТҮЛШ	7,592,699	8	МОНГОЛ БАЗАЛЪТ	3,389,968,415
ХӨХ ГАН	6,278,456	9	Ард Даатгал ХК	2,551,035,583
МОНИНЖБАР	5,725,986	10	БИДИСЕК	2,354,260,408
Э- ТРАНС ЛОЖИСТИКС	5,275,007	11	Мандал Даатгал	1,945,722,998
РЕМИКОН	5,011,024	12	ЖИНСТ УВС	1,520,513,182
Ард Даатгал ХК	3,254,589	13	АЙТҮҮЛС	1,471,697,621
СҮҮ	2,648,674	14	ХАЙ БИ ОЙЛ	1,384,518,928
МЕРЕКС	2,343,489	15	ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА	1,157,668,997
БИДИСЕК	2,327,568	16	МАХИМПЕКС	1,119,914,772
МИК ХОЛДИНГ	2,010,049	17	ШИВЭЭ ОВОО	981,828,134
ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	1,948,272	18	МОНИНЖБАР	959,459,406
ГОВЬ	1,886,955	19	ЖЕНКО ТУР БЮРО	834,756,765
МОНГОЛ ШУУДАН ХК	1,375,011	20	НАКО ТҮЛШ	833,005,630
<b>НИЙТ</b>	<b>418,313,685</b>			<b>173,216,446,440</b>
<b>НИЙТЭД ЭЗЛЭХ ХУВЬ</b>	<b>98.07%</b>			<b>98.43%</b>

Идэвхтэй арилжигдсан 20 үнэт цаасны тоо ширхэг нь нийт арилжигдсан ширхэгийн 98.07 хувь, үнийн дүнгийн 98.43 хувийг тус тус эзэлж байна.

#### Ханшийн өсөлттэй 20 компани

Симбол	Үнэт цаас	2017.12.28	2018.12.31	Ханшийн өөрчлөлт /төг/	Ханшийн өөрчлөлт %/
AZH	АЛТАЙН ЗАМ	603.79	60,200.00	59,596.21	9,870.35
ADU	ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА	35.07	834.77	799.70	2,280.30
HBZ	ХҮННҮ МЕНЕЖМЕНТ	23.21	185.00	161.79	697.07
JLT	НОГООН ХӨГЖИЛ ҮНДЭСНИЙ НЭГДЭЛ	20.91	132.00	111.09	531.28
SUN	ЕВРОАЗИЯ КАПИТАЛ ХОЛДИНГ	251.20	1,150.00	898.80	357.80
LEND	ЛэндМН ББСБ	25.00	71.00	46.00	184.00
CMD	УСЖУУЛАХ	250.00	700.00	450.00	180.00
GNR	ГОНИР	285.00	750.00	465.00	163.16
MNB	МОННАБ	1,853.00	4,500.00	2,647.00	142.85
HCH	Е-МОНИЕ	542.00	1,286.00	744.00	137.27
BNB	БАЯЛАГ НАЛАЙХ	178.00	410.50	232.50	130.62
MVO	МОНГОЛ ШЕВРО	1,180.00	2,580.00	1,400.00	118.64
JGV	ЖУУЛЧИН ГОВЬ	4,131.00	8,880.00	4,749.00	114.96
DAR	ДАРХАН ГУРИЛ ТЭЖЭЭЛ	500.01	920.00	419.99	84.00
HML	ГЛОБАЛ МОНГОЛИА ХОЛДИНГС	1,109.00	2,000.00	891.00	80.34
SSG	СОНСГОЛОН БАРМАТ	621.00	1,086.00	465.00	74.88
DES	ДОРНОД ХУДАЛДАА	11,500.00	20,100.00	8,600.00	74.78
BTG	БАЯНТЭЭГ	11,000.00	18,280.00	7,280.00	66.18
HJL	ЦУУТАЙЖ	188.00	285.92	97.92	52.09
ALD	АЗЫК	1,955.00	2,972.00	1,017.00	52.02

#### Ханшийн бууралттай 20 компани

Симбол	Үнэт цаас	2017.12.28	2018.12.31	Ханшийн өөрчлөлт /төг/	Ханшийн өөрчлөлт %/
MNH	МОНГОЛ НЭХМЭЛ	6,995.00	2,110.00	-4,885.00	-69.84
ABH	АР БАЯНХАНГАЙ	1,800.00	700.00	-1,100.00	-61.11
CHR	ЧАЦАРГАНА	750.00	350.00	-400.00	-53.33
MSC	МОНГОЛ СЕКЬЮРИТИЕС	830.00	400.00	-430.00	-51.81
NIE	НОЁТ ХАЙРХАН	1,000.00	501.82	-498.18	-49.82
TAV	ТАВ	19,000.00	10,000.00	-9,000.00	-47.37
ORD	ОРХОН ДАЛАЙ	3,100.00	1,800.00	-1,300.00	-41.94

SIL	СИЛИКАТ	180.00	105.00	-75.00	-41.67
ITLS	АЙТҮҮЛС	188.24	111.60	-76.64	-40.71
BAN	БАГАНУУР	2,300.00	1,374.00	-926.00	-40.26
HSX	ХИШИГ УУЛ	1,000.00	600.00	-400.00	-40.00
MIB	МОНИНЖБАР	153.33	95.00	-58.33	-38.04
IBA	ИХ БАРИЛГА	5,000.00	3,099.00	-1,901.00	-38.02
BDL	МОГОЙН ГОЛ	11,440.00	7,175.00	-4,265.00	-37.28
MBW	МОНГОЛ БАЗАЛТ	380.00	241.08	-138.92	-36.56
TCK	ТАЛХ ЧИХЭР	29,920.00	19,300.00	-10,620.00	-35.49
MNS	МОННООС	3,799.00	2,500.00	-1,299.00	-34.19
MDR	ФРОНТИЕР ЛЭНД ГРУПП	310.00	205.00	-105.00	-33.87
ADL	АДУУНЧУЛУУН	3,100.00	2,100.00	-1,000.00	-32.26
TAN	ТАХЬ КО	18,480.00	13,400.00	-5,080.00	-27.49

### **1.2 ЗГҮЦ-ны арилжаа**

Тайлант хугацаанд ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа явагдаагүй бөгөөд хоёрдогч зах зээлд нийт 332.9 мянган ширхэг үнэт цаас 33.5 тэрбум төгрөгөөр арилжигдсан байна.

### **1.3 Компанийн бондын арилжаа**

2017 оны 06 дугаар сард “Сүү” ХК-ийн нийтэд санал болгосон 60.0 мянган ширхэг “Сүү бонд”-ыг нийт 6.0 тэрбум төгрөгөөр анхдагч зах зээлд амжилттай арилжсан билээ. 2018 оны 06 дугаар сард энэхүү бондын эргэн төлөлт амжилттай хийгдсэн бөгөөд тайлант хугацаанд хоёрдогч зах зээлийн арилжаагаар 6.3 мянган ширхэг “Сүү бонд”-ыг 631.6 сая төгрөгөөр арилжсан байна.


## **2.Зах зээлийн индикаторууд**

Үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлдог гол индикатор болох Зах зээлийн үнэлгээ, Top-20 индекс болон 2018 оны 2 дугаар сараас тооцож эхэлсэн MSE A, MSE B индексүүдийг 12 дугаар сарын 31-ний байдлаар харуулав.

### **Зах зээлийн үнэлгээ**

2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар МХБ-д бүртгэлтэй олон нийтэд хувьцаа нь арилжигдаж буй компаниудын нийт зах зээлийн үнэлгээ нь 2 их наяд 508.0 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 71.7 тэрбум төгрөгөөр буюу 2.9 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ.

График 3. Зах зээлийн үнэлгээ /сүүлийн 5 жилээр/



*Хамгийн өндөр зах зээлийн үнэлгээтэй 30 компани*

д/д	Компанийн нэрс	Зах зээлийн үнэлгээ
1	АПУ	662,037,985,936.83
2	ТАВАН ТОЛГОЙ	379,716,092,000.00
3	МИК ХОЛДИНГ	305,462,470,000.00
4	ГОВЬ	260,471,762,625.00
5	СҮҮ	70,176,000,000.00
6	МОНГОЛ ШУУДАН ХК	68,120,059,882.89
7	ЕВРОАЗИА КАПИТАЛ ХОЛДИНГ	60,111,525,800.00
8	ЛэндМН ББСБ	56,800,000,000.00
9	УБ БҮК	50,645,787,500.00
10	Мандал Даатгал	32,775,834,000.00
11	ШИВЭЭ ОВОО	30,796,836,795.00
12	БАГАНУУР	28,818,770,640.00
13	ГУТАЛ	25,898,944,000.00
14	ТЕХНИКИМПОРТ	25,896,914,500.00
15	ДАРХАН НЭХИЙ	19,898,622,000.00
16	ТАЛХ ЧИХЭР	19,757,467,900.00
17	Ард Даатгал ХК	19,250,000,000.00
18	УЛСЫН ИХ ДЭЛГҮҮР	18,403,925,000.00
19	ШАРЫН ГОЛ	18,316,605,842.00
20	ТАХЬ КО	15,945,772,200.00
21	БИДИСЕК	15,368,850,000.00
22	МОН.ЦАХИЛГААН ХОЛБОО	14,099,300,420.00
23	МОНГОЛ БАЗАЛЪТ	13,601,010,360.00
24	АРИГ ГАЛ	13,569,348,000.00
25	ХӨВСГӨЛ АЛТАНДУУЛГА	13,134,438,134.00
26	МАТЕРИАЛИМПЕКС	12,984,274,940.00
27	БАЯНГОЛ ЗБ	12,649,643,500.00
28	БЭРХ УУЛ	12,390,352,000.00
29	АТАР ӨРГӨӨ	12,189,520,000.00



30	МОНГОЛ СЕКЬЮРИТИЕС	12,000,000,000.00
<b>Нийт</b>		<b>2,301,288,113,975.72</b>
<b>Нийтэд эзлэх хувь</b>		<b>91.75%</b>

### ТОП-20 индекс

Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 21737.68 нэгж, доод үзүүлэлт 18861.36 нэгж, дундаж үзүүлэлт 20157.00 нэгж байна.

ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 729.8 нэгжээр буюу 3.52 хувиар өсч, 21.466.76 нэгж болсон байна.



### MSE A, MSE B индекс

МХБ нь 2018 оны 02 дугаар сарын 19-ний өдрөөс эхлэн MSE A, MSE B индексийг тооцож эхэлсэн бөгөөд тайлант хугацаанд MSE A индексийн дээд үзүүлэлт нь 11091.79 нэгж, доод үзүүлэлт нь 8872.87 нэгж, дундаж үзүүлэлт нь 9661.84 нэгж байна.

MSE B индексийн хувьд дээд үзүүлэлт нь 10202.94 нэгж, доод үзүүлэлт нь 8284.32 нэгж, дундаж үзүүлэлт нь 9388.79 нэгж байна.

### MSE A болон MSE B индекс



**2017 ОНЫ ҮНЭТ ЦААСНЫ  
АРИЛЖААНЫ ТАЙЛАН**

## 2017 ОНЫ ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ТАЙЛАН

### 3. Үнэт цаасны арилжаа

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 249 удаагийн арилжаагаар 134 компанийн 106.1 сая ширхэг хувьцааг 76.4 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаагаар 6.7 сая ширхэг үнэт цаасыг 630.2 тэрбум төгрөгөөр, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 1.4 сая ширхэг үнэт цаасыг 142.3 тэрбум төгрөгөөр, компанийн бондын анхдагч зах зээлийн арилжаагаар 60.0 мянган ширхэг “Сүү бонд”-ыг 6.0 тэрбум төгрөгөөр, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 41.6 мянган ширхэг бондыг 4.2 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 859.2 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Нийт гүйлгээний үнийн дүнгийн 8.9%-ийг хувьцааны арилжааны гүйлгээний дүн, 89.9%-ийг ЗГҮЦ-ны арилжааны гүйлгээний дүн, 1.2%-ийг компанийн бондын арилжааны гүйлгээний дүн тус тус эзэлж байна.

Хүснэгт 1. Үнэт цаасны арилжаа /2017.12.31-ний байдлаар/

Үнэт цаасны төрөл		Арилжигдсан тоо хэмжээ /сая ширхэг/	Арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг/
Хувьцаа	Анхдагч зах зээл	13.4	1.3
	Хоёрдогч зах зээл	92.7	75.1
ЗГҮЦ	Анхдагч зах зээл	6.7	630.2
	Хоёрдогч зах зээл	1.4	142.3
Компанийн бонд	Анхдагч зах зээл	0.06	6.0
	Хоёрдогч зах зээл	0.04	4.2
<b>Нийт</b>			<b>859.2</b>

Тайлант хугацаанд өдөрт дунджаар 3.4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 459.5 мянган ширхэг үнэт цаас арилжигдсан байна.

Арилжаалагдсан үнэт цаасны үнийн дүнг сүүлийн 3 жилээр харьцуулан харуулбал:  
/Хүснэгт 2/

Хүснэгт 2.

Үнэт цаасны нэр	2015 он	2016 он	2017 он
Хувьцаа /тэрбум төг/	30.5	49.0	76.4
ЗГҮЦ /тэрбум төг/	515.5	299.6	772.5
Компанийн бонд /тэрбум төг/	0.5	-	10.2

### 1.1 Хувьцааны арилжаа


Тайлант хугацаанд нийт 249 удаагийн арилжаагаар 134 компанийн 106.1 сая ширхэг хувьцааг 76.4 тэрбум төгрөгөөр арилжаалсан. Хувьцааны арилжааны 58.3% буюу 44.6 тэрбум төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, үлдэх 41.7% буюу 31.8 тэрбум төгрөгийн гүйлгээг энгийн арилжаа тус тус бүрдүүлж байна.

Үнэт цаасны нэр	Арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг/					
	2015 он		2016 он		2017 он	
	энгийн	багцын	энгийн	багцын	энгийн	багцын
Хувьцаа	27.3	3.1	14.9	34.1	31.8	44.6

Дараах графикаар хувьцааны арилжааны үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулав. /График 1/

График 1.

### Хувьцааны арилжаа /үнийн дүнгээр/



### Багцын арилжаа

Тайлант хугацаанд багцын арилжаагаар Таван толгой, Дархан сэлэнгийн ДЦС, Мах импекс, БиДиСек, Дархан ЗБ, Монгол савхи, АПУ, Мик холдинг, Шарын гол зэрэг нийт 9 компанийн 14.3 сая ширхэг хувьцааг 44.6 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 58.3%-ийг эзэлж байна.

### Тендер саналын арилжаа

Тайлант хугацаанд Монгол даатгал ХХК нь Монгол улсын компанийн тухай хуулийн 57.1, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 22.1.1 болон Монгол улсын санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцааг худалдан авах санал гаргах, хувьцааг худалдан авах ажиллагааны тухай журам”-ыг үндэслэн сайн дурын үндсэн дээр “Хорго хайрхан” ХК-ийн хувьцааны хяналтын багц болон түүнээс дээш хувийг худалдан авахаар санал гаргасан бөгөөд тус саналын арилжаагаар “Хорго хайрхан” ХК-ийн 109.9 мянган ширхэг хувьцааг 30.0 сая төгрөгөөр арилжсан байна.

### *Анхдагч зах зээлийн арилжаа*

2017 оны 11 дүгээр сард “Ай түүлс” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан 13.4 сая ширхэг хувьцааг 1.3 тэрбум төгрөгөөр анхдагч зах зээлд амжилттай арилжсан байна.

### **1.2 ЗГҮЦ-ны арилжаа**

2014 оны 11 дүгээр сараас МХБ-ээр Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаас арилжигдаж эхэлснээс хойш нийт 1.4 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 15.6 сая ширхэг үнэт цаас анхдагч зах зээл дээр арилжигдсан байна.

### *Анхдагч зах зээлийн арилжаа*

2017 онд нийт 44 удаагийн ЗГҮЦ-ны арилжаагаар 6.7 сая ширхэг үнэт цаасыг 630.2 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

Тайлант хугацаанд анхдагч зах зээл дээр нийт 630.2 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжигдсанаас 12 долоо хоногтой үнэт цаас нийт арилжааны 25.0%-ийг, 28 долоо хоногтой үнэт цаас 20.2%, 39 долоо хоногтой үнэт цаас 24.6%, 52 долоо хоногтой үнэт цаас 15.3%-ийг, 2 болон 3 жилийн урт хугацаатай үнэт цаас 14.9%-ийг тус тус эзэлж байна.

### *Хоёрдогч зах зээлийн арилжаа*

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааг 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр нээсэн бөгөөд тайлант хугацаанд нийт 1.4 сая ширхэг үнэт цаас 142.3 тэрбум төгрөгөөр арилжигдсан.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаанд “Новел инвестмент”, “Мирэ Эссет Секьюритис Монгол”, “Голомт капитал”, “БиДиСек ХК”, “Стандарт инвестмент”, “Ард капитал групп”, Гаүли зэрэг ҮЦК-иуд идэвхитэй оролцсон байна.

### **1.3 Компанийн бондын арилжаа**

2017 оны 06 дугаар сард “Сүү” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан өрийн хэрэгслийн анхдагч зах зээлийн арилжаагаар нийт 60.0 мянган ширхэг “Сүү бонд”-ыг 6.0 тэрбум төгрөгөөр амжилттай арилжлаа. Тус бондын хоёрдогч зах зээлийн арилжаагаар нийт 41.5 мянган ширхэг бондыг 4.2 тэрбум төгрөгөөр арилжсан байна.


## **2.Зах зээлийн индикаторууд**

Үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлдог гол индикатор болох Зах зээлийн үнэлгээ, Топ-20 индекс, мөн MSE all index-ийн үзүүлэлтийг 2017 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар гаргалаа.

### *Зах зээлийн үнэлгээ*

2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар МХБ-д бүртгэлтэй олон нийтэд хувьцаа нь арилжигдаж буй компаниудын нийт зах зээлийн үнэлгээ нь 2 их наяд 436.3 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 962.2 тэрбум төгрөгөөр буюу 65.3 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ.


## Зах зээлийн үнэлгээ



## ТОП-20 индекс

Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 24520.35 нэгж, доод үзүүлэлт 11972.11 нэгж, дундаж үзүүлэлт 15511.89 нэгж байна.


ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 8280.87 нэгжээр буюу 66.5 хувиар өсч, 20736.93 нэгж болсон байна.



## MSE ALL индекс

МХБ нь 2015 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн MSE ALL индексийг албан ёсоор тооцож эхлээд байгаа билээ. Тайлант хугацаанд MSE ALL индексийн дээд үзүүлэлт нь 1280.32 нэгж, доод үзүүлэлт нь 814.51 нэгж, дундаж үзүүлэлт нь 950.09 нэгж байна.

MSE ALL индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 285.07 нэгжээр буюу 33.1 хувиар өсч, 1146.31 нэгж болсон байна.





**2016 ОНЫ ҮНЭТ ЦААСНЫ  
АРИЛЖААНЫ ТАЙЛАН**

## 2016 ОНЫ ҮНЭТ ЦААСНЫ АРИЛЖААНЫ ТАЙЛАН

### 4. Үнэт цаасны арилжаа

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар нийт 244 удаагийн арилжаагаар 126 компанийн 93.7 сая ширхэг хувьцааг 49.0 тэрбум төгрөгөөр, ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаагаар 3.1 сая ширхэг үнэт цаасыг 280.4 тэрбум төгрөгөөр, хоёрдогч зах зээлийн арилжаагаар 196.4 мянган ширхэг үнэт цаасыг 19.2 тэрбум төгрөгөөр тус тус арилжиж, нийт 348.7 тэрбум төгрөгийн гүйлгээ хийсэн байна.

Нийт гүйлгээний үнийн дүнгийн 14.1%-ийг хувьцааны арилжааны гүйлгээний дүн, 85.9%-ийг ЗГҮЦ-ны арилжааны гүйлгээний дүн тус тус эзэлж байна.

Хүснэгт 1. Үнэт цаасны арилжаа /2016.12.31-ний байдлаар/

Үнэт цаасны төрөл		Хийгдсэн арилжааны тоо	Арилжигдсан тоо хэмжээ /сая ширхэг/	Арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг/
Хувьцаа	Анхдагч зах зээл	1	33.9	6.3
	Хоёрдогч зах зээл	244	59.8	42.7
ЗГҮЦ	Анхдагч зах зээл	31	3.1	280.5
	Хоёрдогч зах зээл	77	0.196	19.2
<b>Нийт</b>				<b>348.7</b>

Тайлант хугацаанд өдөрт дунджаар 1.4 тэрбум төгрөгийн гүйлгээ хийгдэж, 397.4 мянган ширхэг үнэт цаас арилжигдсан байна.

Арилжаалагдсан үнэт цаасны үнийн дүнг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулан харуулбал: /Хүснэгт 2/

Хүснэгт 2.

Үнэт цаасны нэр	2015 он	2016 он	Өөрчлөлт	Өөрчлөлт /хувиар/
Хувьцаа /тэрбум төг/	30.5	49.0	<b>+18.5</b>	<b>+60.6%</b>
ЗГҮЦ /тэрбум төг/	515.5	299.6	<b>-215.9</b>	<b>-41.9%</b>

#### 1.1 Хувьцааны арилжаа

Тайлант хугацаанд нийт 244 удаагийн арилжаагаар 126 компанийн 93.7 сая ширхэг хувьцааг 49.0 тэрбум төгрөгөөр арилжаалсан. Хувьцааны арилжааны 69.6% буюу 34.1 тэрбум төгрөгийн гүйлгээг багцын арилжаа, үлдэх 30.4% буюу 14.9 тэрбум төгрөгийн гүйлгээг энгийн арилжаа тус тус бүрдүүлж байна.


Үнэт цаасны нэр	Арилжааны үнийн дүн /тэрбум төгрөг/			
	2015 он		2016 он	
	энгийн	багцын	энгийн	багцын

Хувьцаа	27.3	3.1	14.9	34.1
---------	------	-----	------	------

Дараах графикаар хувьцааны арилжааны үзүүлэлтүүдийг өмнөх оны мөн үетэй харьцуулав. /График 1/

График 1.

### Хувьцааны арилжаа /үнийн дүнгээр/



#### Багцын арилжаа

Тайлант хугацаанд багцын арилжаагаар нийт 11 компанийн 41.9 сая ширхэг хувьцааг 34.1 тэрбум төгрөгөөр арилжсан нь нийт хувьцааны арилжааны үнийн дүнгийн 69.6%-ийг эзэлж байна.

#### Тендер саналын арилжаа

Тайлант хугацаанд тендер саналын арилжаагаар “Түшиг уул” ХК-ийн 17.0 мянган ширхэг хувьцааг 8.4 сая төгрөгөөр, “Газар сүлжмэл” ХК-ийн 2.1 мянган ширхэг хувьцааг 88.6 сая төгрөгөөр тус тус арилжсан байна.

#### Анхдагч зах зээлийн арилжаа

2016 оны 1 дүгээр сард “Монгол шуудан” ХК-ийн үнэт цаасны 34 хувь буюу 33.9 сая ширхэг хувьцааг 6.3 тэрбум төгрөгөөр олон нийтэд санал болгон арилжсан байна.

#### 1.2 ЗГҮЦ-ны арилжаа

2014 оны 11 дүгээр сараас МХБ-ээр Засгийн газрын жижиглэнгийн үнэт цаас арилжигдаж эхэлснээс хойш нийт 826.9 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий 8.8 сая ширхэг үнэт цаас анхдагч зах зээл дээр арилжигдсан байна.

#### Анхдагч зах зээлийн арилжаа

2016 онд нийт 31 удаагийн ЗГҮЦ-ны арилжаагаар 3.1 сая ширхэг үнэт цаасыг 280.4 тэрбум төгрөгөөр арилжсан байна.

Тайлант хугацаанд анхдагч зах зээл дээр нийт 280.4 тэрбум төгрөгийн ЗГҮЦ арилжигдсанаас 12 долоо хоногтой үнэт цаас нийт арилжааны 30.3%-ийг, 28 долоо хоногтой үнэт цаас 31.7%, 39 долоо хоногтой үнэт цаас 22.9%, 52 долоо хоногтой үнэт цаас 13.3%-ийг, 2 болон 3 жилийн урт хугацаатай үнэт цаас 1.8%-ийг тус тус эзэлж байна.

### Хоёрдогч зах зээлийн арилжаа

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжааг 2015 оны 01 дүгээр сарын 19-ний өдөр нээсэн бөгөөд тайлант хугацаанд нийт 196.4 мянган ширхэг үнэт цаас 19.2 тэрбум төгрөгөөр арилжигдсан.

ЗГҮЦ-ны хоёрдогч зах зээлийн арилжаанд “Новел инвестмент”, “Дэу секьюритиз”, “Голомт секьюритиз”, “БиДиСек”, “Стандарт инвестмент”, “Ард капитал групп” зэрэг ҮЦК-иуд идэвхитэй оролцсон байна.


## 2.Зах зээлийн индикаторууд

Үнэт цаасны зах зээлийн чиг хандлагыг тодорхойлдог гол индикатор болох Зах зээлийн үнэлгээ, Топ-20 индекс, мөн MSE all index-ийн үзүүлэлтийг 2016 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар гаргалаа.

### Зах зээлийн үнэлгээ

2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар МХБ-д бүртгэлтэй олон нийтэд хувьцаа нь арилжигдаж буй компаниудын нийт зах зээлийн үнэлгээ нь 1 их наяд 474.2 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үеэс 211.7 тэрбум төгрөгөөр буюу 16.8 хувиар өссөн үзүүлэлттэй гарчээ.


График 3. Зах зээлийн үнэлгээ /сүүлийн 5 жилээр/



### ТОП-20 индекс

Тайлант хугацаанд ТОП-20 индексийн дээд үзүүлэлт 12939.50 нэгж, доод үзүүлэлт 10485.71 нэгж, дундаж үзүүлэлт 11550.09 нэгж байна.

ТОП-20 индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 441.53 нэгжээр буюу 3.4 хувиар буурч, 12456.06 нэгж болсон байна.



#### MSE ALL индекс

МХБ нь 2015 оны 02 дугаар сарын 09-ний өдрөөс эхлэн MSE ALL индексийг албан ёсоор тооцож эхлээд байгаа билээ. Тайлант хугацаанд MSE ALL индексийн дээд үзүүлэлт нь 894.94 нэгж, доод үзүүлэлт нь 761.16 нэгж, дундаж үзүүлэлт нь 827.17 нэгж байна.

MSE ALL индексийг өмнөх оны мөн үетэй харьцуулахад 34.64 нэгжээр буюу 3.9 хувиар буурч, 861.24 нэгж болсон байна.

